ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/181/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг:tserenkhandd@audit.gov.mn<br>Аудитор: О.Энхтөр<br>Утас: 95343496 Цахим хаяг:enkhturo@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.25 № 119

танай __________ -ны № __________ -т

ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж үндсэн цалингийн зардлын төсвөөс 9,904.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн зардлын төсвөөс 3,470.5 мянган төгрөгийг ХУРДАН үйлчилгээний машин, урсгал засварын зардлын төсвөөс 287.4 мянган төгрөгийн аж ахуйн материал бэлтгэсэн.
- Тайлант онд татварын 10,563.5 мянган төгрөг, түлш халаалтын 6,462.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 2,762.2 мянган төгрөг, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 1,810.8 мянган төгрөг, бичиг хэргийн 684.6 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны 97.2 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн.

822511000357

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын тавдугаар хавсралттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд иргэдээс хандиваар ирсэн 53,132.5 мянган төгрөгийн, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон 4,581.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэлд тусган, 109,785.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон байна.

**Аудитын гол асуудал**

Өмнөх оны өглөгийг барагдуулахаар төсөвт тусгуулаагүй, Төрийн сангаас зардал хязгаарласантай холбоотойгоор 39,232.6 мянган төгрөгийн өртэй гарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 3 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан, гүйцэтгэлээр 97.0 хувиар дүгнүүлжээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 346,404,820.00 | 422,466,460.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 123,115,820.00 | 124,677,460.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 576,000.00 | 165,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 119,117,820.00 | 122,572,460.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,190,000.00 | 1,190,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,482,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 750,000.00 | 750,000.00 |
| 35600 | Мал амьтад | 223,289,000.00 | 297,789,000.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **414,591,389.00** | **422,466,460.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,030,245,349.03 | 2,209,307,932.62 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,288,381,349.03 | 1,467,623,932.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,016,422,890.43 | 1,130,075,840.43 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (287,100,465.50) | (338,696,894.87) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 125,000,000.00 | 172,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (53,624,999.84) | (9,009,999.99) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 37,068,520.00 | 38,027,161.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,138,161.20) | (12,720,776.61) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 47,180,000.00 | 53,872,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,309,037.99) | (15,970,183.13) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 108,667,146.00 | 123,667,146.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (25,416,794.10) | (31,475,151.42) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 130,892,000.00 | 130,892,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 291,961,100.00 | 311,221,451.81 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (67,220,848.77) | (84,658,661.53) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 741,864,000.00 | 741,684,000.00 |
| 39301 | Програм хангамж | 360,000.00 | 360,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (180,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 741,504,000.00 | 741,504,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,030,245,349.03** | **2,209,307,932.62** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,444,836,738.03** | **2,631,774,392.62** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 27,424,264.70 | 39,232,657.07 |
| **413** | **Өглөг** | 27,424,264.70 | 39,232,657.07 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 21,313,380.70 | 15,136,634.17 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 97,250.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 6,110,884.00 | 23,998,772.90 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 6,110,884.00 | 23,314,172.90 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | (0.00) | 684,600.00 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **27,424,264.70** | **39,232,657.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,417,412,473.33 | 2,592,541,735.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 389,151,152.00 | 389,151,152.00 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан | 389,151,152.00 | 389,151,152.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,659,472,966.19 | 1,834,602,228.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,513,933,645.23 | 1,605,972,966.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 145,539,320.96 | 228,629,262.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 368,788,355.14 | 368,788,355.14 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,417,412,473.33** | **2,592,541,735.55** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,444,836,738.03** | **2,631,774,392.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **984,826,034.00** | **884,622,418.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 159,253,034.00 | 39,944,218.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,265,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 138,623,034.00 | 39,804,218.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 365,000.00 | 140,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 825,573,000.00 | 844,678,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 825,573,000.00 | 844,678,200.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **279,385,000.00** | **459,810,963.74** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 279,385,000.00 | 459,810,963.74 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 14,000,000.00 | 7,452,950.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 14,000,000.00 | 7,452,950.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 265,385,000.00 | 369,060,013.74 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 83,298,000.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,264,211,034.00** | **1,344,433,381.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,118,613,713.84** | **1,113,197,484.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,047,382,499.21 | 1,087,529,629.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 519,080,556.02 | 612,946,754.36 |
| 210101 | Үндсэн цалин | 261,068,947.93 | 275,982,689.10 |
| 210102 | Нэмэгдэл | 177,874,993.09 | 282,714,300.60 |
| 210104 | Урамшуулал | 40,061,358.00 | 17,606,803.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 40,075,257.00 | 36,642,961.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,747,173.23 | 77,584,663.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,871,064.21 | 51,751,842.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,061,664.13 | 6,090,345.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,102,255.96 | 3,507,292.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,472,834.67 | 3,045,172.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,239,354.26 | 13,190,009.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 56,902,559.32 | 60,296,136.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,470,847.32 | 8,264,424.14 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 50,531,712.00 | 50,531,712.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,900,000.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 74,999,167.00 | 37,084,155.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,975,100.00 | 4,010,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,418,764.00 | 18,879,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,214,803.00 | 2,449,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,390,500.00 | 11,744,110.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 9,846,650.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 9,846,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 15,516,500.00 | 12,130,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,516,500.00 | 12,130,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 144,639,561.00 | 108,571,726.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,104,500.00 | 108,337,276.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 234,450.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 1,095,061.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 171,496,982.64 | 169,069,544.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,801,340.00 | 27,725,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,695,642.64 | 141,343,744.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 71,231,214.63 | 25,667,854.86 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,923,500.00 | 16,183,250.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 17,502,000.00 | 11,583,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,421,500.00 | 4,600,250.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 48,307,714.63 | 3,782,588.86 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,307,714.63 | 3,782,588.86 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 5,702,016.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,702,016.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,118,613,713.84** | **1,113,197,484.08** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **145,597,320.16** | **231,235,897.66** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,057,999.20 | 2,606,635.44 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,057,999.20 | 2,606,635.44 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (57,999.20) | (2,606,635.44) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **145,539,320.96** | **228,629,262.22** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,041,060,073.00** | **952,808,987.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 215,487,073.00 | 108,130,787.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,265,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 194,857,073.00 | 107,990,787.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 365,000.00 | 140,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 825,573,000.00 | 844,678,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 825,573,000.00 | 844,678,200.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,041,060,073.00** | **952,808,987.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,042,060,073.00** | **952,808,987.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **902,642,289.37** | **927,141,132.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 504,904,937.75 | 615,964,363.90 |
| 210101 | Үндсэн цалин | 206,751,568.00 | 273,152,063.28 |
| 210102 | Нэмэгдэл | 221,437,060.75 | 288,562,805.96 |
| 210104 | Урамшуулал | 40,272,002.00 | 17,606,803.16 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 36,444,307.00 | 36,642,691.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,286,308.30 | 80,743,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,659,399.87 | 59,943,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,666,200.00 | 5,200,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,333,099.31 | 2,600,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,296,309.12 | 2,600,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,331,300.00 | 10,400,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 50,961,175.32 | 44,130,097.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,471,047.32 | 8,264,425.24 |
| 210302 | Түлш, халаалт | 44,590,128.00 | 34,365,672.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,900,000.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 62,404,567.00 | 28,028,695.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,141,600.00 | 2,827,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,310,764.00 | 17,397,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,214,803.00 | 2,449,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,737,400.00 | 5,353,650.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,568,100.00 | 9,846,650.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,568,100.00 | 9,846,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 15,516,500.00 | 12,130,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,516,500.00 | 12,130,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 144,705,561.00 | 108,571,726.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,170,500.00 | 108,337,276.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 234,450.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 1,095,061.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,295,140.00 | 27,725,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,295,140.00 | 27,725,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **139,417,783.63** | **25,667,854.86** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,923,500.00 | 16,183,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 17,502,000.00 | 11,583,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,421,500.00 | 4,600,250.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 116,494,283.63 | 3,782,588.86 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 116,494,283.63 | 3,782,588.86 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 5,702,016.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,702,016.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)** | **1,042,060,073.00** | **952,808,987.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 389,151,152.00 | 368,788,355.14 | 1,513,933,645.23 | 2,271,873,152.37 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **389,151,152.00** | **368,788,355.14** | **1,513,933,645.23** | 2,271,873,152.37 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 145,539,320.96 | 145,539,320.96 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **389,151,152.00** | **368,788,355.14** | **1,659,472,966.19** | 2,417,412,473.33 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **389,151,152.00** | **368,788,355.14** | **1,659,472,966.19** | 2,417,412,473.33 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (53,500,000.00) | (53,500,000.00) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **389,151,152.00** | **368,788,355.14** | **1,605,972,966.19** | 2,363,912,473.33 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 228,629,262.22 | 228,629,262.22 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **389,151,152.00** | **368,788,355.14** | **1,834,602,228.41** | 2,592,541,735.55 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **908,533,800.00** | **838,303,611.14** | **70,230,188.86** | 92.3 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 908,533,800.00 | 838,303,611.14 | 70,230,188.86 | 92.3 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 889,663,800.00 | 822,120,361.14 | 67,543,438.86 | 92.4 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 645,950,000.00 | 615,964,363.90 | 29,985,636.10 | 95.4 |
| Үндсэн цалин | 197,400,000.00 | 273,152,063.28 | (75,752,063.28) | 138.4 |
| Нэмэгдэл | 370,430,000.00 | 288,562,805.96 | 81,867,194.04 | 77.9 |
| Урамшуулал | 46,800,000.00 | 17,606,803.16 | 29,193,196.84 | 37.6 |
| Гэрээт ажлын хөлс | 31,320,000.00 | 36,642,691.50 | (5,322,691.50) | 117.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,515,000.00 | 44,130,097.24 | 7,384,902.76 | 85.7 |
| Гэрэл, цахилгаан | 9,000,000.00 | 8,264,425.24 | 735,574.76 | 91.8 |
| Түлш, халаалт | 39,515,000.00 | 34,365,672.00 | 5,149,328.00 | 87.0 |
| Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 1,500,000.00 | 1,500,000.00 | 50.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Хангамж, бараа материалын зардал** | 35,000,000.00 | 22,116,900.00 | 12,883,100.00 | 63.2 |
| Бичиг хэрэг | 5,000,000.00 | 2,827,750.00 | 2,172,250.00 | 56.6 |
| Тээвэр, шатахуун | 20,000,000.00 | 11,576,000.00 | 8,424,000.00 | 57.9 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 2,359,500.00 | 640,500.00 | 78.7 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,000,000.00 | 5,353,650.00 | 1,646,350.00 | 76.5 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000,000.00 | 9,846,650.00 | 153,350.00 | 98.5 |
| Урсгал засвар | 10,000,000.00 | 9,846,650.00 | 153,350.00 | 98.5 |
| **Томилолт, зочны зардал** | 13,000,000.00 | 12,130,000.00 | 870,000.00 | 93.3 |
| Дотоод албан томилолт | 13,000,000.00 | 12,130,000.00 | 870,000.00 | 93.3 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,005,000.00 | 9,462,750.00 | 4,542,250.00 | 67.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,000,000.00 | 9,228,300.00 | 1,771,700.00 | 83.9 |
| Даатгалын үйлчилгээ | 800,000.00 | 234,450.00 | 565,550.00 | 29.3 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 165,000.00 | - | 165,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,000.00 | - | 90,000.00 | - |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | - | 450,000.00 | - |
| Газрын төлбөр | 1,500,000.00 | - | 1,500,000.00 | - |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,450,000.00 | 27,725,800.00 | 11,724,200.00 | 70.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 39,450,000.00 | 27,725,800.00 | 11,724,200.00 | 70.3 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,870,000.00 | 16,183,250.00 | 2,686,750.00 | 85.8 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 18,870,000.00 | 16,183,250.00 | 2,686,750.00 | 85.8 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,870,000.00 | 11,583,000.00 | 1,287,000.00 | 90.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,000,000.00 | 4,600,250.00 | 1,399,750.00 | 76.7 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **908,533,800.00** | **838,303,611.14** | **70,230,188.86** | 92.3 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 908,533,800.00 | 838,303,611.14 | 70,230,188.86 | 92.3 |
| Орон нутгийн төсвөөс | 908,533,800.00 | 838,303,611.14 | 70,230,188.86 | 92.3 |

**2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Нэмэлт санхүүжилт СТ-4-2** (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **110,722,787.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 110,722,787.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 105,020,771.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,911,795.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,821,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 90,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 99,108,976.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 99,108,976.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,702,016.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,702,016.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,702,016.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **110,722,787.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 110,722,787.00 |

| | | |
|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,199,498.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,090,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 72,433,289.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 95,482.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа [1] -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

### 3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Бараа материалын тайланд 17,397.7 мянган төгрөгийн шатахууныг шууд зардлаар тайлагнасныг залрууллаа.
- Нэмэлт санхүүжилтийн орлогын 2,592.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн дансанд, 75,492.7 мянган төгрөгийг дансны ангиллаар зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

Залруулагдаагүй нийт 14,536.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Нийт 14,536.4 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын ээлжийн амралтын цалинг 8, 9 дүгээр саруудад 873.8 мянган төгрөгөөр давхардуулан илүү тооцож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой**

Илрүүлэлт: Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн зардлын төсвөөс 3,470.5 мянган төгрөгийг ХУРДАН үйлчилгээний машин, урсгал засварын зардлын төсвөөс 287.4 мянган төгрөгийн бээлий, саван аж ахуйн материал, үндсэн цалингийн төсвөөс 9,904.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", "Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын тавдугаар хавсралт"-тай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх.

**Хоёр. Цалингийн зардалтай холбоотой**

Тайлант онд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 1,810.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 2,762.2 мянган төгрөг, татварын 10,563.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны 97.2 мянган төгрөг, түлш халаалтын 6,462.2 мянган төгрөг, бичиг хэргийн 684.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үүссэн өр төлбөрийн тооцоо нийлэн барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*

*(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар | Бараа материалын тайланд 17,397.7 мянган төгрөгийн шатахууныг шууд зардлаар тайлагнасан | 1 | 17,397.7 | 1 | 17,397.7 | - | - | 1 | 17,397.7 | - | - | - | - |
| | Нэмэлт санхүүжилтийн орлогын 2,592.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн дансанд, 75,492.7 мянган төгрөгийг дансны ангиллаар зөрүүтэй тайлагнасан | 1 | 78,084.7 | - | - | 1 | 78,084.7 | 1 | 78,084.7 | - | - | - | - |
| **Дүн** | | 1 | 95,482.4 | **1** | 17,397.7 | **1** | 78,084.7 | **2** | 95,482.4 | **-** | **-** | **-** | **-** |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар | Сумын засаг даргын ээлжийн амралтын цалинг 8,9 дүгээр саруудад 873.8 мянган төгрөгөөр давхаруулан илүү тооцож олгосон. | 1 | 873.8 | 1 | 873.8 | - | - | - | - | - | - |
| | Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн зардлаас 3,470.5 мянган төгрөгийг ХУРДАН үйлчилгээний машин, урсгал засварын зардлаас 287.4 мянган төгрөгийн бээлий, вок, саван аж ахуйн материал, үндсэн цалингийн зардлаас 9,904.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зарцуулсан. | 1 | 13,662.6 | - | - | - | - | 1 | 13,662.6 | - | - |
| | Тайлант онд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 1,810.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 2,762.2 мянган төгрөг, татварын 10,563.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны 97.2 мянган төгрөг, түлш халаалтын 6,462.2 мянган төгрөг, бичиг хэргийн 684.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | | **3** | **14,536.4** | **1** | 873.8 | **-** | **-** | **2** | 13,662.6 | **-** | **-** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | | **1** | | | | **1** | | |